

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
эрдэм шинжилгээний бичиг

Боть XXXIX (433)

2015

(122-130)

МОНГОЛ МАЛГАЙД ДҮРСЛЭГДСЭН ШУВУУНЫ ДҮРИЙН УЧИР ¹

Ц. Отгонсүрэн *

Оршил

Хүн төрөлхтний соёлын нэн дэвшилттэй бүтээлийн нэг бол «хувцас» агаад тэр нь хэдэн зуун мянган жилийн түүхийн явцад өөрчлөгдөн хувирсаар иржээ. Байгаль цаг уурын онцгой нөхцөл (мөстлөг)-өөс болоод эртний хүмүүс өвс ургамлаар хийсэн хувцсаа халж, хүйтнээс биеэ хамгаалаахын тулд арьс, үсээр хувцас хийж өмсөх болсон нь хувцасны төрөл зүйл үүсэн бүрэлдэх суурь болсон гэж үзэх талтай. Энэ нь явсаар хувцасны хууль цаазыг тогтоон, мөрдөх хэмжээнд хүрч, өөрөөр хэлбэл хувцас нь зөвхөн өдөр тутмын хэрэглээнээс хальж, авын, тайлга тахилгын, гоёлын гэх мэт хэрэглээгээр иргэдийн зэрэг дэвийг ялгах ялгамжаа болтлоо хөгжсөн байна. Тэрхүү хувцасны нэгэн бүрэлдэхүүн хэсэг–малгай бүрх, нэн ялангуяа малгай бүрхэд дүрслэгдсэн нэгэн дүрсийн талаар энэхүү өгүүлэлд өгүүлсү.

Анхны хэмээгдэх малгайнаас эхлэн XX зууны эхин үе хүртэл Монголчуудын өмсөж асан малгай бүрхийн зүйлийг аман болон бичгийн сурвалжууд толь бичиг, түүхийн болон түүхэн сэдэвт ном, зохиол зэргээс шүүрдэн 350 гаруй зүйл нэрийг олж түүвэрлэлээ. Хэдий эл тоо бүхэлдээ монгол малгай бүрхийн төрөл зүйлийн тоо гэж баттай үзэх аргагүй ч баримжаа тоо гарах буй за. Тэдгээр малгай бүрх нь хоорондоо хэлбэр дүрсээрээ ялгагдах агаад өөрийн гэсэн хэрэглээ зориулалт хийгээд утга учиртай юм. Сонирхолтой баримт гэвэл эл судалгааны хүрээнд түүвэрлэсэн малгай бүрхийн нэрийн зүйлээс 150 гаруй нь хэлбэр дүрсээр нэрлэсэн нэр, бусад нь хийсэн эд, хэрэглээ зориулалт болон гадаад нэрс байна².

Тэгвэл «малгай» хэмээх ерөнхий нэрийн хувьд тодруулга хийе.

Энэхүү «малгай» хэмээх үг нь нэрнээсээ эхлэн гүн утга учрыг агуулдаг агаад Монголын язгуурын шашин болох бөө мөргөлийн үзлээр төрт ёсны бэлгэдэлтэй төдийгүй

¹) Энэхүү өгүүлэл “Монгол малгай дахь шувуу болон хүний нүүрний дүрсийн учир” нэрээр БНХАУ-ын Баруун Хойтын Үндэстний Их Сургуулийн “Journal of Northwest University for Nationalities”. 2006.I. №37. 58-63-р тал. /ISSN:1002-9125/ сэтгүүлд хэвлэгдсэн бөгөөд энэ удаад нэмж дэлгэрүүлэн толилуулж байна.

* МУИС, Шинжлэх ухааны сургууль

²) Отгонсүрэн. Ц. Малгай бүрхийн уламжлалт нэр томъёоны асуудалд. Магистрын зохиол. МУИС. МХСС. УБ. 2002.

“язгуур утгаараа «**mala+qai**» (Одоо ч зарим нутагт **malxaa** эсвэл **malxai, maxlaa** гэдэг) буюу «**малааныг халхлах**», «**халзныгаа хаах**», «**оюуны сүнсийг далдлан хамгаалах**»³ гэсэн утгатай бөлгөө. Иймд монгол хүн аливаа ёс хүндэтгэл, золгох, цагаалах юм уу тахил тайлгын үед малгайгаа заавал өмсдөг нь оюуны сүнсээ хамгаалах, мөн ёс төрийг эрхимлэхийн давхар утгатай аж. Түүнчлэн зулай бол оюуны сүнсний орц, гарц болдог гэж үзэх төдийгүй нялх хүүхдийн зулай хамгийн сүүлд битүүрдэг тул зулайг хамгаалдаг зэрэг нь малгайн ёс дэг болон сүнс сүлдний бэлгэдэл, үзэл итгэлтэй холбоотой явж ирсэн хэмээн үзэж болно.

“... Мөн «**Үрийн хайрханд даатгахдаатгал**»-д

“Малгай мэтээр манаж

Сүүдэр мэтээр дагалдаж”(Хурцбаатар 1991:260) гэсэн хоёр шад

шүлэг гарч байгаа нь малгайг ямар нэгэн юм манаж явдаг гэсэн санаа буюу сүүдэр шиг байнга дагалдаж явах ёстой гэсэн үг аж. Энэ нь утгаа малгайгаараа сүнс сүлднийхээ орц, гарц болох зулайгаа хааж, онгод тэнгэр, газар лусын эздийг хүндэтгэн, сүнс сүлдээ биедээ оршоож байгаа гэсэн утга бололтой”⁴

Чухам энэ учраар малгай бүрх нь бусад хувцаснаас илүү эрхимд тооцогддогийн сацуу өөрийн гэсэн утга санаа, бэлгэдлийг агуулсан эд ангиас бүрддэг аж. Тиймээс энд зарим эд ангийн бэлгэдэлт утгын талаар товч дурдъя.

Малгайг ерөнхийд нь:

1. Оройн хэсэг
2. Туурган хэсэг
3. Ёроол буюу хормойн хэсэг

хэмэн хуваавал оройн хэсэгт мандал бадралыг бэлгэдсэн эд анги байх агаад туурган хэсэгт нь амар түвшин, тайван амгаланг бэлгэдсэн хэсэг, ёроол хэсэгт нь муу муухай хийгээд аюулаас хамгаалан, сэрэмжилсэн утга бэлгэдэл бүхүй эд анги байна гэж үзэж болно. Жишээлбэл:

Оройн хэсэгт:

1. Малгайн **орой**-г эрдэмтэд олон янзаар тайлбарладаг. ...Монголчуудын хувцасны дотроос хурц, шулуун, харилтгүйн утга бэлгэдсэн шовгор оройтой малгай нь хүний биеийн ёс, төртэй мандан бадарч явахын бэлгэ оршсон⁵ гэдэг. Мөн шовгор оройтой, бөмбөгөр суурьтай малгайн **орой** нь тэнгэр өөд тэмүүлсэн, цэнгэн мандахын бэлгэ юм⁶.
2. Малгайн оройд байх **сампин** нь олон ястны эв нэгдэл юм. Эв нэгдлийн хүчээр улс орон маань сүмбэр уул мэт бат болох юм⁷.
3. Сампин уяаны дээд **гогцоо** нь сар, **уяа** нь бат бэх, доод **тав** нь нарыг төлөөлдөг⁸.

³) Дулам.С. *Монгол малгай – бэлгэдлийн цогцлол*. “Дээлтэй монгол” ОУЭШХурлын товхимол. Улаанбаатар. 2010. 109-110

⁴) Бум-Очир. Д. *Бөөгийн зан үйл дэх төөрөг хаях ёс*. МУИС. Монгол Судлалын Сургууль. ЭШ бичиг. 14-р боть. УБ. 1999

⁵) Нямбуу. Х. *Хамгийн эрхим ёсон*. УБ. 1991.

⁶) Ядамсүрэн. Ү. *БНМАУ-ын ардын хувцас*. Цомог. УБ. 1967.

⁷) Сампилдэндэв. Х. *Монгол домгийн чуулган*. УБ. 1999.

4. Мөн эл хэсэгт байх улаан **залаа** нь монгол угсаатан гурван цагт галын заль мэт мандан бадрахын бэлгэдэл утга юм⁹.

Туурган хэсэгт:

5. Харин түүнээс дөрвөн **хүрээ** салаалсан нь гал голомтыг төлөөлдөг¹⁰.

6. Малгайн 32 **ширээс**-ийг монгол ястнууд хэмээн ихэнх эрдэмтэд үздэг.

Ёроол хэсэгт:

7. Үүнд **хивсэг** багтах агаад түүний өнгө хар байдаг нь Монголчуудыг бүчин суусан дайсан¹¹ гэхээсээ илүү тэдгээр дайсныг даран устгах санаа бэлгэдлийг агуулж байна¹².

8. Хивсэгний ар дахь сэтэрхий нь тэдгээр дайснуудыг сэт татан устгахын бэлгэдэл¹³ юм.

Эдгээрээс гадна энэ мэт бэлгэдлийн нэгэн илрэл болгож Монголчууд өөрсдийн тотем шүтээнээ эрхим дээд болсон малгайдаа дүрсэлдэг байсан нь түүхийн сурвалж бичиг болон археологийн олдворуудаас харж болно. Магадгүй малгайд буй хэлбэр дүрс, хээ хуар зэргээр тухайн хүнийг танихаас гадна тэр үеийн соёл суртахууныг тодорхойлж болох мэт санагдана. Тэдгээрийн дотроос энд нэгэн дүрсийн талаар онцолсу.

Монгол малгайд дүрслэгдсэн шувууны дүр

Малгай бүрхийн зүйл нь биет бодитой малгай, хүн чулуу, зураг болон бичгийн дурсгалын зэрэг хэд хэдэн янзын хэлбэртэйгээр бидний үед олдож, судалгааны үндсэн хэрэглэгдэхүүн болсоор байна. Тэдгээрээс үзвэл бидний өвөг дээдэс намхан оройтой, шовгор оройтой, хавтгай оройтой гэх мэт элдэв хэлбэрийн малгай өмсөж байсан нь хэрэглэгдэхүүнээс тодорхой авч тэдгээрийг нягтлах явцад зарим малгайд амьд биетийн дүр ажиглагдаж байна. Тодруулбал шувууны дүр юм. Үүнийг урагшлуулан мөшгин хөөвөл маш эрт цаг буюу бүр хүй нэгдлийн үеэс улбаатай агаад энэ нь тэдний тотем шүтлэгтэй холбоотой аж. Тэгвэл гагц малгайн бүрхийн зүйлд тэрхүү тотемоо дүрсэлдэггүй байжээ. Өөрөөр хэлбэл энэхүү малгайн зүйлд тотем шүтээнээ дүрслэх болсон нь нэлээн хожуу үетэй холбон үзэж болох бөгөөд юутай ч Хүннүгээс өмнөх үеийн малгай бүрхийн зүйлд энэ мэтийн дүрс бүхий олдвор одоогоор олдсон нь үгүй. Иймээс үүнээс үүдэн өмнө нь ямар эд эдлэлд ийн дүрсэлдэг талаарх асуулт гарах лавтай.

Үүний нотлох тодорхой баримт сэлт гэвэл хадны зураг, хүрлийн ба түүнээс хойшхи үед холбогдох археологийн олдворуудыг дурдаж болно. Тухайлбал:

1. Хадны зураг:

- Монгол нутагт буй хүрэл зэвсгийн үеийн зураг сүгүүд нь дөрөвдөгч галбын үеийн бөгөөд хүрэн элгэн чулуун дээр сийлсэн. Энэ үед улаан зосоор зурсан дургууд орох бөгөөд

⁸⁾ Ядамсүрэн. Ү. *БНМАУ-ын ардын хувцас*. Цомог. УБ. 1967.

⁹⁾ Дулам. С. *Монгол бэлгэдэл зүй*. Өнгөний бэлгэдэл зүй, зүг чигийн бэлгэдэл зүй. Дэд дэвтэр. УБ. 2000. 57

¹⁰⁾ Ядамсүрэн. Ү. *БНМАУ-ын ардын хувцас*. Цомог. УБ. 1967.

¹¹⁾ Хувцас судлаачид ийн тайлбарладаг.

¹²⁾ Отгонсүрэн.Ц. *Монгол малгай дахь өнгөний бэлгэдэл*. Монгол судлал. МУИС. МХСС-ийн ЭШ-ний бичиг. XXIII боть, XXVII дэвтэр. УБ. 2004

¹³⁾ Нямбуу. Х. *Хамгийн эрхим ёсон*. УБ. 1991. 19.

дөрвөлжин зураасан дотор олон арван цэг тавьж, гадна нь хүн, морь буюу шувууны дүрс зурсан байна¹⁴

2. Эд эдлэл:

- Гоёл чимэглэлийн хүрэл эдлэл манай аль ч нутгаас элбэг олддог. а. Араатан жигүүртэн зэрэг амьтдын дүрст тээг, товруу, даруулга; б. Гаж дүрст амьтдын загварт махчин шувууны толгойн дүрст зүүлт, товруу, тээг зэрэг¹⁵

- Сүхбаатар аймгийн орон нутгийг судлах музейд байгаа хэдэн хүрэл хутганы нэг дээрх зэллэн нисч байгаа шувууны дүрс¹⁶

- Чандманаас олдсон шувууны толгойн дүрст оройтой шөвөг¹⁷

- Дундговь аймгийн орон нутгийн судлах музейд байгаа шувуун толгойтой, хоёр бөхтэй тэмээ, болон шувууны толгойнуудыг сүлжилдүүлэн хийсэн модны өмнө чононд уруулж байгаа морины дүрстэй чимэг¹⁸

- Сүжигтийн амны доод биед байсан «Уст булш» хэмээх булшны авсыг өнгийн будгаар будаж, ёроол хананд шувуу нисгэж зурсан¹⁹ зэрэг болно. Энэ бүхнээс үзэхэд шувууг ихэд дээдлэн эрхимлэж, эд агуурсаа даатгаж, өөрсдийн онгон болгон тахин шүтдэг байсан нь дээр дурдсан сүг зурагнаас тодорхой харагдаж байна. Гэхдээ энэ мэт шувуу шүтэх нь зөвхөн Монголчуудын дунд бус Египет болон Грек зэрэг эртний соёл иргэншилт ард түмний дунд ч бас байжээ. Тэд зарим шувууг агнадаг хэдий ч шонхор мэтийн шувууг фараоны бэлгэдэл, бас хамгаалагч хэмээн үзэж, шүтдэг байсныг дашрамд тэмдэглүүштэй.

Тэр үеийн хүмүүсийн голлон эрхлэх аж ахуй нь ан агнуур агаад түүгээрээ хоол хүнсээ залгуулж, арьс үсээр нь хувцас, хунар зэргийг хийж өмсөн, амь зууж, зарим үед олзтой, заримдаа хоосон ирдэг байсан бөгөөд түүнийгээ эзэд сахиус ба байгалийг захирагч далд юм буй хэмээн ухааран, түүнтэй холбон тайлбарлаж, тэдгээр эзэд сахиусыг аргадахын тулд ангийн арвин олзтой ирэхийг ерөөн хүсэмжилж түүнийгээ бэлгэдэн хад чулуун дээр зурах буюу сийлдэг ба заримдаа түүнээ шүтэж, бас тухайн ангийн дүрээр онго хийн тахидаг хийгээд олзгүй ирсэн үедээ мөнөөх эзэн сахиустайгаа холбон тайлбарлаж, түүнээ аргадан элдэв үйлийг үйлддэг байв. Гэхдээ тэрхүү эзэд сахиусыг аргадахын тулд гагц дүр хийн тахиx бус дуу дуулан, бүжиг бүжиглэх гэх мэт үйлдлүүдийг бас үйлддэг байж. Чухам тэр мэт ёсноос шүтэн дээдлэх ёс буюу тотемизм буй болж улмаар шашин шүтлэгийн эх тавигдсан хэмээн үздэг.

Харин тэдгээр онгод сахиусыг онголон тахиx зэрэг элдэв үйлдэл нь тухайн овгийн байснаа улам боловсронгуй болж нарийссаар айл өрх хүртэл үйлдэх болсон гэж хэлж болно. Энэ нь тэдгээр хүмүүсийн оюун санааны хөгжилтэй холбоотой болох нь дамжиггүй. Гэсэн хэдий ч овог аймгийн онгон тахилгын ёс хэвээр хадгалагдсаар. Гагцхүү онгод сахиусын дүрүүд хийгээд тэдгээрийг тахиx үйлдэл, арга маяг нь цагийн эрхээр өөрчлөгдөн хувирсаар иржээ. Тухайлбал анх элдэв амьтны дүрсээ хад чулуун дээр зурж сийлж, дуу дуулан, бүжиг бүжиглэх зэрэг үйлдлийг тухайн овгийн ахлагч гүйцэтгэдэг

¹⁴⁾ Сэр-Оджав. Н. *Монголын эртний түүх*. УБ. 1977. 41

¹⁵⁾ Мөн тэнд. 38

¹⁶⁾ Мөн тэнд. 36

¹⁷⁾ Мөн тэнд. 54

¹⁸⁾ Мөн тэнд. 66

¹⁹⁾ Мөн тэнд. 95

байж. Дараа нь тэрхүү онгод шүтээнээ хад чулуун дээр бус өөрсдийн эд эдлэл дээрээ дүрслэх болсон нь өмнө дурдсан олдворуудаас тодорхой мэдэгдэнэ. Гэвч энд өгүүлэх малгай бүрхийн зүйл дээр шувуу дүрсэлсэн нь нэлээн хожуу үед холбогдох агаад юутай ч Хүннү (МЭӨ 3-р зуун)-ээс өмнөх үед хамаатай олдвор хараахан олдоогүй гэдгийг дахин дурдалтай. Тэдгээр малгай бүрхийн зүйлд дүрслэгдсэн шувуу нь Монгол газраа төр улсаа мандуулж асан тухайн үндэстэн бүрийн шашин шүтлэг хийгээд тэдний ертөнцийг үзэх үзэлтэй ихээхэн холбоотойгоор өөрчлөгдөж байжээ. Гэхдээ энэ нь зөвхөн нэг үндэстэнд хамаарах зүйл биш юм.

Тодорхой дурдвас: Монгол газар анхны төр улсаа байгуулж асан Хүннү гүрний үеийн булшнаас олдсон хатан хүний болон бөөгийн малгай нь шар шувууны дүртэй (*Зураг 1*) байхад хэдэн зууны дараах Түрэгийн эзэнт гүрний үеийн гол дурсгал болох хүн чулуу дахь малгайд бүргэд юм уу шонхор адил шувуу (*Зураг 2*), харин бүр сүүлд XIII зуунаас хойшхи үе буюу дундад зууны үед холбогдох малгай бүрхийн зүйлд шонхор шувуу (*Зураг 3*) дүрслэгдсэн зэргээс хоёр зүйл анхаарал татахуйц байна. Үүнд:

1. Тэдгээр нь голдуу малгайн орой болон туурган хэсгүүдэд дүрслэгдсэн;

2. Тэдгээр нь энгийн ардын бус хаад ноёд, ихэс дээдэс, цэргийн эрхтэн дархтны өөрөөр хэлбэл сурвалжит хүний малгай, дуулгад дүрслэгдсэн.

Гэхдээ энд цаг хугацааны хувьд зөрүүтэй зүйл бас ажиглагдсан нь Хүннүгийн үеийн малгай дахь шувуу нь хатан хүний юм уу бөө, удганыхад дүрслэгджээ. Учир нь бөө мөргөл нь эхийн эрхт ёсны үед үүссэн гэх бөгөөд эмэгтэй хүний байр суурь илүү давамгай байж. Тиймээс Хүннүгийн үед бөө мөргөдтийг шүтэх явдал илүү давамгай байсан болов уу гэсэн дүгнэлтэд хүрлээ. Гэтэл дараах үеийн малгайн шувууд нь хаан, жанжин, цэргийн эрхтэний малгайд дүрслэгдсэн нь эрэгтэй хүний байр суурь илүү болсон хийгээд дээр дурдсан элдэв үйлдлүүдийг овгийн ахлагч нар гүйцэтгэдэг байсантай холбон тайлбарлаж боломжтой.

Эл хоёр зүйлийн санаа нь цаанаа нэгдмэл гэж хэлж болно. Учир нь мандал бадрал хийгээд тайван амгаланг илэрхийлэхийн сацуу шувуу гэдэг бол тэнгэрийн амьтан, харин ихэс дээдэс, язгууртныг тэнгэр язгууртай, тэнгэрийн хүү хэмээн үздэг бөгөөд энэ утгаараа цаад язгуур санаа нь нийлж буй гэлтэй. Гэхдээ яагаад Хүннүгийн үед шар шувуу, Түрэгийн үед бүргэд, түүнээс хойш шонхор дүрсэлдэг байсан бэ гэдэг нь улам нарийвчлан судлууштай зүйлийн нэг бөлгөө.

Юутай ч шувуудын дүр байдал хожим ч бөөгийн малгайд хэвээр хадгалагдан үлдсэн. Учир нь бөөгийн малгайн оройн хэсэгт шувууны өдийг хадсаныг саналтай. Гэхдээ овог, ясаараа өөр өөр шувууны өд хадгагийг бөө судлаачид хэдийнээ тогтоосон нь “Хүннү бөөгийн малгайн ирмэгийг тойруулан шар шувууны сөд хадсан байхад XX зууны үеийн монгол бөөгийн малгайн орой, ирмэгээр шар шувуу, бүргэд, сойрын өд сөд хадсан байдаг. Тухайлбал хотгойд, барга, Даяндээрхийн халх, Сайн ноён аймгийн халх бөөгийн малгайн оройд шар шувууны сөд бүхий арьс ч хадсан байна. Дархад, хуулар, уйгур болон Тувагийн тож нутгийн бөөгийн оройгүй боолт хэлбэрийн малгайн дээд ирмэгээр бүргэдийн өд хаджээ”²⁰ гэсэн жишээ татахад тодорхой болох болов уу.

²⁰⁾ Пүрэв. О. *Монгол бөөгийн шашин*. УБ. 1999. 183, 184

Дүгнэлт: Дээрх бүхнээс үзэхэд хад чулуун дээр зурдаг байсан шувуугаа малгайдаа дүрслэх болсон нь сүлд шүтлэгээ өөрийн биедээ улам ойртуулах санаа хийгээд овгийн ахлагч нар элдэв дом шившлэгийн үйлдлийг гүйцэтгэдэг байсан нь хожмоо ихэс дээдсийн малгайд тэрхүү шувуу дүрслэгдэх болсон шалтгаан гэж үзмээр байна. Өөрөөр хэлбэл отог омгийн ахлагч нар өдөн малгай өмсдөг байсныг дундад зуунаас хойш ноёд, түшмэдийн малгайдаа хадах отгын эхи үндэс гэж үзэж болно. Юутай ч ихэс дээдэс бол тэнгэр язгууртай, тэнгэрийн үр сад, харин шувуу бол тэнгэрийн амьтан тул шувуудыг шүтэх нь зүйн хэрэг биз ээ.

Харин бүр сүүлийн үед өвөг дээдсээ шүтэх болсны нэг илрэл нь бөөгийн малгайд буй хүний нүүрний дүр юм (*Зураг 4*). Тэгэхээр энэ хоёр дүрс нь сүлд шүтлэгийн хөгжлийн үе шатыг илтгэж байна. Тодруулбал балар эрт цагт хүмүүс өөрсдийгээ тэнгэр язгуурт чоно, цагаан галуу, бөртэ чоно, хоо маралаас гаралтай хэмээн сэтгэж, тэдгээр амьтдаа шүтэн дээдэлж байжээ. Гэтэл тэр нь цаг хугацаа хийгээд тэдний оюун сэтгэлгээний хөгжил, хувирлаас болж өөрсдийн гарал үүслийг үзэх үзэлтэд өөрчлөлт гарсангэсэн үг. Үүнийг энгийн үгээр тайлбарлавал тэд өөрсдийгээ амьтнаас гаралтай биш гагцхүү хүнээс гаралтай юм байна гэдгийг ухааран өвөг дээдсээ шүтэх болсон гэж үзэж болно.

Энд дурдан буй малгай бүрхийн зүйлд дүрслэгдсэн шувууны болон хүний нүүрний дүрс нь балар эртнээс нааши хүмүүсийн өөрсдийн уг гарлаа үзэх тэдний сэтгэлгээг илтгэх бөгөөд өөрсдийн язгуур гарвалдаа бие, овог угсаа болон эд агуурсаа даатгах санаагаар шүтэн дээдэлж байсны гэрч болж байна.

НОМ ЗҮЙ

1. Бум-Очир. Д. (1999). *Бөөгийн зан үйл дэх төөрөг хаях ёс*. МУИС. Монгол Судлалын Сургууль. ЭШ-ний бичиг. 14-р боть. УБ.,
2. Дулам. С. (2000). *Монгол бэлгэдэл зүй. Өнгөний бэлгэдэл зүй, зүг чигийн бэлгэдэл зүй*. Дэд дэвтэр. УБ.,
3. Ёнсог (1992). *Монгол шаашин суртахууны тойм*. ОМАХХорлоо.,
4. Mounir A. Farah, Andrea Berens Karls (1999). *World History. The human experience. The Early ages*.
5. Clencoe McGraw-Hill. The USA.,
6. Нямбуу.Х. (1991). *Хамгийн эрхим ёсон*. УБ.,
7. Отгонсүрэн.Ц. (2002). *Малгай бүрхийн уламжлалт нэр томъёоны асуудалд*. Магистрийн зохиол. УБ.,
8. Отгонсүрэн.Ц. (2004). *Монгол малгай дахь өнгөний бэлгэдэл*. Монгол судлал. МУИС. МХСС-ийн ЭШ-ний бичиг. 13-р боть. 23-р дэвтэр. УБ.,
9. Сампилдэндэв.Х. (1999). *Монгол домгийн чуулган*. УБ.,
10. Сэр-Оджав.Н. (1977). *Монголын эртний түүх*. УБ.,


11. Пүрэв.О. (1999). *Монгол бөөгийн шашин*. УБ.,
12. Ядамсүрэн.Я. (1967). *БНМАУ-ын ардын хувцас*. Цомог. УБ.,

ABSTRACT


Costume is one of wonderful creatures by humans. In the primitive times, people would put them to shelter their body from the sun, wind and cold. Then, they also managed to wear them with different purposes.

This article will tell about Mongolian traditional headdress, as a domain of Mongolian nomadic tribes' totem was placed upon, that is to say, to be depicted. The bird was first displayed on rocks and their possessions, but subsequently on their headdress. According to this study regarding to the figures on headdresses, the Hunnus worshipped owl, the Turkic eagle, but the Mongolians falcon during the Great Mongol Empire.

Хавсралт



Зураг 1



Зураг 2



Зураг 3



Зураг 4